



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/183/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2025 оны 02 дугаар сарын 21

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	21
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.5.1 Завсрын аудитын талаар.....	21
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	21
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДХН	Засаг даргын нөөц хөрөнгө



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
Н.ЭНХЖАРГАЛ ТАНАА

2025.02.21 № 2/23

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020194

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 23 зорилтын хүрээнд 101 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 95.5 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	427,142,437.51	573,273,781.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,090,000.00	3,678,500.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,090,000.00	3,678,500.00
3121	Төгрөг	22,090,000.00	3,678,500.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	22,090,000.00	3,678,500.00
33	АВЛАГА	26,882,650.54	183,865,201.54
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	265,713.00	265,713.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7,773,077.64	180,488,171.54
335	Бусад авлага	18,843,859.90	3,111,317.00
3351	Байгууллагаас авах авлага	18,843,859.90	3,111,317.00
34	УРЬДЧИЛГАА	3,327,457.18	2,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	3,327,457.18	2,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	374,842,329.79	383,730,079.51
351	Түүхий эд материал	287,473,013.10	243,488,769.74
35110	Тусгай зориулалттай материал	14,588,812.75	22,850,527.91
35130	Эм боох материал	272,884,200.35	220,638,241.83
354	Хангамжийн материал	87,369,316.69	140,241,309.77
35410	Бичиг хэргийн материал	3,320,800.00	2,413,500.00
35420	Аж ахуйн материал	13,255,744.00	14,078,594.00
35430	Сэлбэг хэрэгсэл	30,000.00	550,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,039,195.00	545,223.18
35450	Барилгын засварын материал	10,227,880.00	10,227,880.00
35460	Хүнсний материал	48,742,143.05	101,672,557.95
35470	Бусад хангамжийн материал	10,753,554.64	10,753,554.64
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	986,590,121.04	931,239,790.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	986,590,121.04	931,239,790.99
392	Биет хөрөнгө	821,528,142.01	766,321,040.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	817,117,098.51	817,117,098.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-144,682,181.26	-173,253,372.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,700,000.00	113,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-95,716,666.86	-111,366,666.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	307,770,721.51	337,003,421.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-197,050,326.65	-231,467,450.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	103,414,580.34	103,414,580.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	-83,385,083.58	-89,186,569.73
39214	Бусад үндсэн хөрөнгө	420,000.00	420,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-60,000.00	-60,000.00
393	Биет бус хөрөнгө	165,061,979.03	164,918,750.06
39301	Програм хангамж	1,760,000.00	1,760,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,273,020.97	-1,416,249.94
39303	Бусад биет бус хөрөнгө	164,575,000.00	164,575,000.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,413,732,558.55</u>	<u>1,504,513,572.04</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>13,523,720.00</u>	<u>9,805,093.14</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,523,720.00	9,805,093.14
413	Өглөг	13,523,720.00	9,805,093.14
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	8,388,193.14
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,523,720.00	00.00
4136	Бусад өглөг	00.00	1,416,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	1,416,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,400,208,838.55</u>	<u>1,494,708,478.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,400,208,838.55	1,494,708,478.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	755,146,079.04	755,146,079.04
51101	Өмч: - төрийн	755,146,079.04	755,146,079.04
512	Хуримтлагдсан үр дүн	-111,126,049.44	-16,626,409.09
51210	Өмнөх үеийн үр дүн	-111,126,049.44	-111,126,049.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	94,499,640.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	756,188,808.95	756,188,808.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,413,732,558.55</u>	<u>1,504,513,572.04</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,995,095,782.48	5,331,699,513.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,036,487,818.48	701,329,766.66
120	Нийтлэг татварын бус орлого	1,036,487,818.48	701,329,766.66
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,958,607,964.00	4,630,369,746.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,643,279,036.00	4,449,862,806.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,643,279,036.00	4,449,862,806.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,328,928.00	180,506,940.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	57,912,678.00	31,014,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	61,144,990.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	222,813,680.00	84,156,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	34,602,570.00	4,190,650.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,209,886,238.39	4,995,552,305.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,061,886,238.39	4,995,552,305.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,577,664,698.92	2,447,433,107.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	870,020,202.55	1,201,062,889.03
210101	Үндсэн цалин	493,312,315.55	643,263,935.43
210102	Нэмэгдэл	186,558,163.00	348,451,303.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	79,525,000.00	89,790,000.00
210104	Урамшуулал	110,624,724.00	119,557,650.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,829,852.03	151,866,235.25
210201	Тэтгэврийн даатгал	74,015,810.38	102,682,259.80
210202	Тэтгэмжийн даатгал	8,686,060.11	12,206,121.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,790,448.07	7,427,326.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,667,046.90	5,910,103.40
210205	Эрүүл мэндийн даатгал	16,670,486.57	23,640,423.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,806,741.11	94,734,652.26
210301	Гэрэл, цахилгаан	8,687,961.11	8,062,484.26
210302	Түлш, халаалт	59,980,800.00	65,978,880.00
210303	Цэвэр, бохир ус	17,137,980.00	20,693,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	169,684,900.59	69,251,050.20
210401	Бичиг хэрэг	15,008,680.00	12,880,205.00
210402	Тээвэр, шатахуун	46,972,643.00	43,266,324.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,873,465.24	2,762,271.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	665,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,423,441.00	9,142,250.00
210408	Бараа материал акталсны зардал	82,741,671.35	00.00
2105	Нормативт зардал	143,647,065.26	543,940,015.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	143,647,065.26	543,940,015.22
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,280,140.00	13,608,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	80,000.00
210604	Урсгал засвар	11,280,140.00	13,528,300.00
2107	Томилолт, зочны зардал	12,328,000.00	15,253,100.00
210702	Дотоод албан томилолт	12,328,000.00	15,253,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,752,267.60	14,019,385.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,660,000.00	9,832,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,200.00	168,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,159,067.60	3,436,800.00
210807	Газрын төлбөр	643,000.00	326,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,315,529.78	343,697,480.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,141,463.00	160,088,250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	865,000.00	99,026,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,309,066.78	84,583,030.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,484,221,539.47	2,548,119,198.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,395,217,224.00	2,454,696,764.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	785,159,700.00	1,040,565,694.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	599,238,724.00	1,393,223,370.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,818,800.00	20,907,700.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,684,315.47	91,010,487.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,684,315.47	91,010,487.52
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,384,297.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,384,297.38
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	320,000.00	27,650.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	320,000.00	27,650.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	148,000,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	148,000,000.00	00.00
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	148,000,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>785,209,544.09</u>	<u>336,147,207.25</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,113,691,592.76	241,647,566.90
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	321,642.44	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	1,113,369,950.32	241,647,566.90
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,113,691,592.76	-241,647,566.90
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-328,482,048.67</u>	<u>94,499,640.35</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,133,740,378.64</u>	<u>4,661,504,171.04</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,133,740,378.64	4,661,504,171.04
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,643,279,036.00	4,449,862,806.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,643,279,036.00	4,449,862,806.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	490,461,342.64	211,641,365.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	57,912,678.00	31,014,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	61,144,990.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	222,813,680.00	91,929,477.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	192,157,140.44	27,551,996.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,118,815,378.64</u>	<u>4,678,115,671.04</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,118,815,378.64	4,678,115,671.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,626,820,761.53	2,117,308,300.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	870,285,915.55	1,194,240,543.00
210101	Үндсэн цалин	493,933,012.05	631,894,026.41
210102	Нэмэгдэл	186,464,718.60	356,587,315.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	79,326,807.41	88,263,173.46
210104	Урамшуулал	110,561,377.49	117,496,027.40

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,829,852.03	150,300,388.14
210201	Тэтгэврийн даатгал	74,015,810.38	101,861,330.78
210202	Тэтгэмжийн даатгал	8,686,060.11	12,238,474.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,790,448.07	6,126,147.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1,667,046.90	5,598,767.07
210205	Эрүүл мэндийн даатгал	16,670,486.57	24,475,668.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,806,741.11	94,734,652.26
210301	Гэрэл, цахилгаан	8,687,961.11	8,062,484.26
210302	Түлш, халаалт	59,980,800.00	65,978,880.00
210303	Цэвэр, бохир ус	17,137,980.00	20,693,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,873,195.24	43,376,971.20
210401	Бичиг хэрэг	5,804,330.00	3,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,768,850.00	31,479,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,930,203.24	2,762,271.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	665,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,704,812.00	4,335,100.00
2105	Нормативт зардал	176,623,577.00	21,881,253.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	163,623,577.00	21,881,253.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,000,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,745,640.00	304,737,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,008,000.00	287,241,800.00
210604	Урсгал засвар	10,737,640.00	17,495,800.00
2107	Томилолт, зочны зардал	12,328,000.00	15,253,100.00
210702	Дотоод албан томилолт	12,328,000.00	15,253,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,227,587.60	26,449,038.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,218,788.00	18,961,253.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,200.00	168,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,075,599.60	6,737,200.00
210807	Газрын төлбөр	643,000.00	326,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	236,100,253.00	266,334,755.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	235,445,253.00	163,033,555.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	655,000.00	103,301,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,491,994,617.11	2,560,807,370.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,395,217,224.00	2,456,896,764.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	785,159,700.00	1,051,226,068.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	599,238,724.00	1,382,562,996.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,818,800.00	23,107,700.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,684,315.47	91,010,487.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,684,315.47	91,010,487.52
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	2,384,297.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,384,297.38
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,093,077.64	10,515,821.54
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,093,077.64	10,515,821.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14,925,000.00</u>	<u>-16,611,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,870,000.00	1,800,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,870,000.00	1,800,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,870,000.00	1,800,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,870,000.00	1,800,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,870,000.00</u>	<u>-1,800,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	13,055,000.00	-18,411,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,035,000.00	22,090,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,090,000.00	3,678,500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	217,355,999.23	00.00	1,728,690,887.22
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	217,355,999.23	00.00	1,728,690,887.22
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-328,482,048.67	00.00	-328,482,048.67
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-111,126,049.44	00.00	1,400,208,838.55
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-111,126,049.44	00.00	1,400,208,838.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-111,126,049.44	00.00	1,400,208,838.55
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	94,499,640.35	00.00	94,499,640.35
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	755,146,079.04	756,188,808.95	-16,626,409.09	00.00	1,494,708,478.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,591,022,900.00	4,358,852,318.48	232,170,581.52	94.9

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,591,022,900.00	4,358,852,318.48	232,170,581.52	94.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,946,430,400.00	1,920,367,054.48	26,063,345.52	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,145,846,600.00	1,145,846,600.00	00.00	100.0
210101	Үндсэн цалин	659,692,800.00	631,894,026.41	27,798,773.59	95.8
210102	Нэмэгдэл	321,478,800.00	308,193,372.73	13,285,427.27	95.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	69,796,200.00	88,263,173.46	-18,466,973.46	126.5
210104	Урамшуулал	94,878,800.00	117,496,027.40	-22,617,227.40	123.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,618,300.00	143,896,791.02	3,721,508.98	97.5
210201	Тэтгэврийн даатгал	98,908,500.00	95,707,091.02	3,201,408.98	96.8
210202	Тэтгэмжийн даатгал	12,177,400.00	12,177,400.00	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,088,700.00	6,088,700.00	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	6,088,700.00	5,568,600.00	520,100.00	91.5
210205	Эрүүл мэндийн даатгал	24,355,000.00	24,355,000.00	00.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,868,600.00	94,734,652.26	8,133,947.74	92.1
210301	Гэрэл, цахилгаан	8,374,100.00	8,062,484.26	311,615.74	96.3
210302	Түлш, халаалт	72,535,200.00	65,978,880.00	6,556,320.00	91.0
210303	Цэвэр, бохир ус	21,959,300.00	20,693,288.00	1,266,012.00	94.2
2104	Хангамж, бараа материалын зардал	46,019,000.00	43,376,971.20	2,642,028.80	94.3
210401	Бичиг хэрэг	6,003,600.00	3,600,000.00	2,403,600.00	60.0
210402	Тээвэр, шатахуун	32,808,000.00	31,479,600.00	1,328,400.00	96.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,499,600.00	2,762,271.20	-262,671.20	110.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,203,200.00	1,200,000.00	3,200.00	99.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,504,600.00	4,335,100.00	-830,500.00	123.7
2105	Нормативт зардал	369,900.00	150,000.00	219,900.00	40.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	341,700.00	150,000.00	191,700.00	43.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,200.00	00.00	28,200.00	00.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	309,710,200.00	306,537,600.00	3,172,600.00	99.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	291,754,200.00	289,041,800.00	2,712,400.00	99.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	460,200.00	00.00	460,200.00	00.0
210604	Урсгал засвар	17,495,800.00	17,495,800.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	15,278,000.00	15,253,100.00	24,900.00	99.8
210702	Дотоод албан томилолт	15,278,000.00	15,253,100.00	24,900.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,550,700.00	7,487,785.00	1,062,915.00	87.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	45,800.00	00.00	45,800.00	00.0

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
210803	Даатгалын үйлчилгээ	310,400.00	200,925.00	109,475.00	64.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	230,700.00	168,660.00	62,040.00	73.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	63,500.00	55,000.00	8,500.00	86.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,737,700.00	6,737,200.00	500.00	100.0
210807	Газрын төлбөр	1,162,600.00	326,000.00	836,600.00	28.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	170169100.00	163083555.00	7,085,545.00	95.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	169,210,600.00	163,033,555.00	6,177,045.00	96.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	958,500.00	50,000.00	908,500.00	05.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2644592500.00	2438485264.00	206,107,236.00	92.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,644,592,500.00	2,438,485,264.00	206,107,236.00	92.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,253,761,000.00	1,051,226,068.00	202,534,932.00	83.8
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,386,135,300.00	1,382,562,996.00	3,572,304.00	99.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,696,200.00	4,696,200.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	211,641,365.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	211,641,365.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,741,246.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,393,943.00
210102	Нэмэгдэл	48,393,943.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,403,597.12
210201	Тэтгэврийн даатгал	6,403,597.12
2105	Нормативт зардал	21,731,253.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,731,253.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,961,253.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,961,253.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103251200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	103,251,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12900118.92
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,900,118.92
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,384,297.38
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	10,515,821.54
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	211,641,365.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	211,641,365.04
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	31,014,900.00

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан		
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,144,990.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,156,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,325,074.54

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн чиглэлийн хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлдэг “Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, зохистой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан дундаж наслалтыг уртасгахад оршино” гэсэн эрхэм зорилго тавин ажиллажээ.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Удирдлага зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын чиглэл”-ээр хэрэгжүүлэх хүрээнд 10 зорилт 29 арга хэмжээ, “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэл”-ийн хүрээнд 2 зорилт 16 арга хэмжээ, “Нийгмийн эрүүл мэндийн чиглэл”-ийн хүрээнд 8 зорилт 32 арга, хэмжээ, “Хяналт шалгалтын чиглэл”-ийн хүрээнд 3 зорилт 24 арга, хэмжээ нийт 23 зорилт 101 арга хэмжээг тусгасан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Дарга Н.Энхжаргал, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч П.Мөнх-Эрдэнэ нар зурж, нярваар Ш.Мандал ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол (Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам)
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 83 дугаар тогтоол (Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам)

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүргийг Эрүүл мэндийн яамны Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Сангийн сайдын 2018 оны тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын жишиг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрддөг, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-1 стандартын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,504,513.6 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 90,781.0 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	427,142.5	573,273.8	146,131.3
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	22,090.0	3,678.5	(18,411.5)
Авлага	26,882.7	183,865.2	156,982.5
Урьдчилгаа	3,327.5	2,000.0	(1,327.5)
Бараа материал	374,842.3	383,730.1	8,887.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	986,590.1	931,239.8	(55,350.3)
Үндсэн хөрөнгө	1,508,757.4	1,537,990.1	29,232.7
Хуримтлагдсан элэгдэл	(522,167.3)	(606,750.3)	(84,583.0)
Нийт хөрөнгө	1,413,732.6	1,504,513.6	90,781.0
Өр төлбөр	13,523.7	9,805.1	(3,718.6)
Засгийн газрын хувь оролцоо (Эздийн өмч)	1,400,208.9	1,494,708.5	94,499.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,413,752.6	1,504,513.6	90,781.0

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,678.5 мянган төгрөг байгаа нь ахмадын сангийн дансны үлдэгдэл байна.

Авлагын дансны эхний үлдэгдэл 183,865.2 мянган төгрөг болж 156,982.5 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой авлага 265.7 мянга, техникийн хяналтын барьцаа дансанд байршуулсан автомашины мөнгө 170,000.0 мянга, оны эцэст буцаан төвлөрүүлсэн 10,488.2 мянга, сумдын эмийн эргэлтийн сангаас авах авлага 3,111.3 мянган төгрөгийг авлагаар тусгасантай холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 2,000.0 мянган төгрөг болж 1,327.5 мянган төгрөгөөр буурсан нь шатахууны зарцуулагдаагүй картын үлдэгдэл болох 2,000.0 мянган төгрөгийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 383,730.1 мянган төгрөг болж өмнөх оноос 8,887.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 186,136.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, "Ник" ХХК-аас 836.0 мянган төгрөгийн шатах тослох материал, "Чоно гол трейд" ХХК-иас 55,676.5 мянга, ХӨСҮТ-өөс 442,860.6 мянга, ЭМЯ-аас 174,524.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд 590,989.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, сумдын Эрүүл мэндийн төвүүд, аймгийн Өрхийн ЭМТ, Нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төвүүдэд нийт 260,156.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хуваарилсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,537,990.1 мянган төгрөг болж 29,232.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,800.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, "Би ай эм би" ХХК-иас 634.7 мянга, ЭМЯ-аас 26,798.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч тоног төхөөрөмж дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 9,805.1 мянган төгрөг байгаа нь ХХОАТ-ын 8,388.2 мянга, "Ашид мөнх тод" ХХК-д 571.4 мянга, "Брэнд эй ди эс" ХХК-д 378.0 мянга, "Монбэт" ХХК-д 467.5 нийт 9,805.1 мянган мянган өр төлбөр үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,494,708.5 мянган төгрөг болж 94,499.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн 94,499.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,291,818.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр, нийт зарлагыг 4,291,818.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг анх 50,645.9 мянган төгрөгөөр бууруулан улсын төсвөөс 4,241,172.9 мянган төгрөгөөр баталсан байна. Дахин нэг удаа тодотгон 349,850.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 4,591,022.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 4,591,022.9 мянган санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,591,022.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн зардлын гүйцэтгэл 4,358,852.4 мянган төгрөг буюу 94.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 232,170.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	71603 Эрүүл мэндийн бодлого, удирдлага	4,591,022.9	4,358,852.4	232,170.5	94,9
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,928,783.1	1,908,161.1	20,622.0	98,9
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,644,592.5	2,438,485.3	206,107.2	92,2
3	83112 Хөтөлбөр төслийн дотоод удирдлага	17,647.3	12,206.0	5,441.3	69,2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын нэмэлт үйл ажиллагааны хүрээнд 35,325.1 мянга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс авсан хандив, тусламжаар 31,014.9 мянга, дээд шатны төсөв захирагчаас 84,156.4 мянга, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 61,145.0 мянга нийт 211,641.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, орон нутгийн нэмэгдэлд 54,797.5 мянга, эм, эмнэлгийн хэрэгслийн зардалд 21,731.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 18,961.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 103,251.2 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 2,384.3 мянга, улсын төсөвт 10,515.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

ЭМГ-ын даргын 2023.12.28-ны өдөр “Баянхонгор аймгийн ЭМГ-ын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд 365,439.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “сумын ЭМТ-ийн эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх” нэг тендерийг НТШ-ын журмаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн ЭМГ-ын дарга худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2 удаа тодотгон баталсан ба төлөвлөгөөнд “Өрхийн ЭМТ-үүдэд яаралтай тусламжийн авто машин нийлүүлэх” 100,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг харьцуулалтын аргаар, “Баянхонгор аймгийн ЭМГ-т авто машин нийлүүлэх” 170,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг НТШ-ын журмаар зохион байгуулахаар төлөвлөсөн.

Тус байгууллага нь 365,440.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерийг 17 багцад НТШ-ын аргаар зохион байгуулсан бөгөөд 14 багцад гүйцэтгэгч шалгарч 292,819.1 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Хүснэгт № 0 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

(мянган төгрөг)

Багц	Гүйцэтгэгчийн нэр	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан огноо	Тендер шалгаруулалт-ын журам
Багц-1	“Тэгш-Анар” ХХК	1,923.0	1,912.8	2024.03.11	НТШ
Багц-2	“Монос трейд” ХХК	26,501.3	16,434.0	2024.03.11	НТШ
Багц-3		6,440.0			Үнийн дүн өндөр тул шалгаараагүй
Багц-4	“Тэгш-Анар” ХХК	1,950.0	1,730.0	2024.03.11	НТШ
Багц-5	“Тэгш-Анар” ХХК	10,730.0	7,713.0	2024.03.11	НТШ
Багц-6	“Монос трейд” ХХК	24,284.0	20,880.2	2024.03.11	НТШ
Багц-7		32,015.0			Үнийн дүн өндөр тул шалгаараагүй
Багц-8		921.5			Оролцогч оролцоогүй
Багц-9	“Мөнхийн тун” ХХК	12,732.5	13,375.0	2024.03.07	НТШ
Багц-10	“Түвшин энэрэл” ХХК	16,585.5	16,585.5	2024.05.03	НТШ
Багц-11	“Айвико” ХХК	26,128.0	26,120.0	2024.03.11	НТШ
Багц-12а	“Агниста фарм” ХХК	41,860.0	41,716.0	2024.03.07	НТШ
Багц-12б	“Мөнхийн тун” ХХК	2,100.0	1,890.0	2024.03.07	НТШ
Багц-13	“Мөнхийн тун” ХХК	40,563.2	37,793.6	2024.03.07	НТШ
Багц-14	“Мөнхийн тун” ХХК	41,355.0	27,485.0	2024.03.07	НТШ
Багц-15	“Ази фарм” ХХК	14,400.0	14,400.0	2024.05.03	НТШ
Багц-16	“Евро фарм” ХХК	21,392.0	21,392.0	2024.05.03	НТШ
Багц-17	“Эм эс ай си си” ХХК	43,559.0	43,392.0	2024.03.07	НТШ
		365,440.0	292,819.1		

“Мөнхийн тун” ХХК нь 12,732.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй багц-9-д Монгол Улсын гарал үүсэлтэй дотоодын үйлдвэрийн бараа оруулсан тул 13,375.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд тендерийн эмийн захиалгаар 142 нэр төрлийн 731,074 ширхэг эм эмнэлгийн хэрэгслийг тендер шалгарсан компаниас 292,819.1 мянган төгрөгийн худалдан авалт хийхээр гэрээнд тусгасан байна.

Ерөнхий гэрээгээр 8 компаниас 59,392.1 мянган төгрөгийн 81 нэр төрлийн эм эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийсэн байна.

Өрхийн ЭМТ-үүдэд яаралтай тусламжийн авто машин нийлүүлэх тендерт “Бүдума” ХХК шалгарч 95,700.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж нэг 23,925.0 мянган төгрөгийн үнэтэй 4 автомашин нийлүүлэгдсэн байна.

Баянхонгор аймгийн ЭМГ-т авто машин нийлүүлэх тендерийг 4 удаа зарлагдсан боловч оролцогч компаниуд гомдол гаргаж гүйцэтгэгч шалгараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 67 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсөв 4,591,022.9 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 4,591,022.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 45,910.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 29,841.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийг хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна. Аудитаар төрийн хэмнэлтийн хуультай холбоотой зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст 196 тушаал, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4,610,352.5 мянган төгрөгийн орлогын 41 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2,965,228.3 мянган төгрөгийн 255 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шилэн дансны цахим сайтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 97,754.0 мянган төгрөгийн орлогын 13 гүйлгээ мэдээлээгүй байсныг нөхөн мэдээлүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 243,578.3 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, зөрчлийг арилгах, зөрчил давтан гаргахгүй байх 243,578.3 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн хэрэгжилтийг FAS системд оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	243,578.3	3	243,578.3	100
Нийт дүн	3	243,578.3	3	243,578.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Байгууллагын даргын 2024.07.09-ний өдрийн “Урамшуулал олгох тухай” А/84 дүгээр тушаалаар нягтлан бодогч, төсвийн төлөвлөлт, санхүүгийн бүртгэл мэдээлэл, тайлангийн нэгтгэл хариуцсан мэргэжилтэн, эд хариуцагч нарт балансын урамшуулалд 3 сарын үндсэн цалин буюу 11,169.0 мянган төгрөг олгосон байна. Иймд дараагийн аудитаар дээрх урамшууллыг хавтгайруулан олгосон эсэх асуудлыг авч үзэх шаардлагатай.

2. ЭМС-ын 2024.11.15-ны өдрийн "Тоног төхөөрөмж орлогод авч, хуваарилах тухай" А/452 дугаар тушаал тус байгууллагад хуваарилсан 250,444,301.8 мянган төгрөгийн хөрөнгөөс 76,293.3 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч 174,151.0 мянган төгрөгийн хөрөнгө ирээгүй тул бүртгээгүй байна.

3. ЭМЯ-аас ЭМС-ын 2024.11.15-ны өдрийн "Тоног төхөөрөмж орлогод авч, хуваарилах тухай" А/452 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн эрүүл мэндийн системийн 26 байгууллагад 861,638.0 мянган төгрөгийн хөрөнгө хуваарилсан ба 365,484.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн, 8,153.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан боловч бүртгээгүй, 488,000.2 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн аваагүй байна. Хүлээн аваагүй хөрөнгийг УИХ-ын гишүүд иргэдэд шууд тараасан байна. Иймд улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэгдэж хуваарилагдсан хөрөнгийг бүрэн хүлээн авч бүртгэл, тайланд тусгаж байгаа эсэхийг анхаарах шаардлагатай.

4. Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилт хугацаандаа орохгүйгээс Баянхонгор аймгийн эрүүл мэндийн системийн 25 байгууллагад 4,697,936.0 мянган төгрөгийн авлага үүссэн байна. Иймд санхүүжилтийг хугацаанд нь олгож байгаа эсэх асуудлыг үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,575.5 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 2,575.5 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн 2,575.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 29,841.6 мянган төгрөгийн гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 27,266.2 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.2 Албан шаардлага

5.2.1. Баянхонгор аймгийн Засаг даргын 2024.07.23-ны өдрийн "Эрүүл мэндийн газрын даргад урамшуулал олгох тухай" А/424 дүгээр захирамжаар даргад балансын урамшуулалд 1 сарын үндсэн цалин 1,933.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг өгөв.

5.2.2. Баянхонгор аймгийн хэмжээнд тендерийн эмийн захиалгаар 142 нэр төрлийн 731,074 ширхэг эм эмнэлгийн хэрэгслийг 292,819.1 мянган төгрөгөөр худалдан авалт хийхээр тендерт шалгарсан компаниудтай гэрээ байгуулсан ба нийлүүлэгч компаниудын гэрээг дүгнэхдээ нийт худалдан авалтын дүнг гаргаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн эм нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийн тендерээр нийлүүлсэн 2024 оны эмийн тооцоог гарган гэрээг дүгнэх, цаашид тендерийн эм нийлүүлэгч байгууллагуудын гүйцэтгэлд хяналт тавьж байх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 12,732.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Багц-9 тендерт “Мөнхийн тун” ХХК шалгарч 13,375.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан нь батлагдсан төсөвт өртгөөс 642.5 мянган төгрөгөөр илүү байна.

Энэ нь Төсвийн тухай 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.12-т “Захиалагч тендерийн харьцуулах үнийг хийсвэрээр тооцсон нь гэрээний үнийг өөрчлөх үндэслэл болохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн батлагдсан төсвөөс хэтрүүлэн гэрээ хийхгүй байх, цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 12,732.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Багц-9 тендерт "Мөнхийн тун" ХХК шалгарч 13,375.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан нь батлагдсан төсөвт өртгөөс 642.5 мянган төгрөгөөр илүү байна.	1	642.5	-	-	1	642.5	-	-
Баянхонгор аймгийн Засаг даргын 2024.07.23-ны өдрийн "Эрүүл мэндийн газрын даргад урамшуулал олгох тухай" А/424 дүгээр захирамжаар даргад балансын урамшуулалд 1 сарын үндсэн цалин 1,933.0 мянган төгрөгийг олгосон байна.	1	1,933.0	-	-	1	1,933.0	-	-
Баянхонгор аймгийн хэмжээнд тендерийн эмийн захиалгаар 142 нэр төрлийн 731,074 ширхэг эм эмнэлгийн хэрэгслийг 292,819.1 мянган төгрөгөөр худалдан авалт хийхээр тендерт шалгарсан компаниудтай гэрээ байгуулсан ба нийлүүлэгч компаниудын гэрээг дүгнэхдээ нийт худалдан авалтын дүнг гаргаагүй байна.	1	0	-	-	1	-	-	-
Дүн	3	2,575.5	-	-	3	2,575.5	-	-

-----oOo-----